



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014.09.28 № 1/1528

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах журам”, “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний загварыг хавсралтаар хүргүүлэв.

Журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгож байна.

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

My doc. Bodlogiin heregjiltiin gazar A-5

1002722



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2014 оны 09 сарын 22 өдөр

Дугаар A/124

Улаанбаатар хот


Журмын хэрэгжилтийг хангах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17<sup>1</sup> дугаар зүйл, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм"-ийн 16-ийн "к" заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний загварыг хоёрдугаар хавсралтаар, Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, дүгнэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Б.Батбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн Дэд дарга /Д.Золжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Ц.УРТНАСАН

